



БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ



УРИАЛГА

Дэлхийн хүн төрөлхтний өмнө тулгараад байгаа байгаль орчны тулгамдсан асуудлын нэг нь цөлжилт болоод байгаа билээ. Цөлжилт, газрын доройтолд өртөмтгий хуурай, гандуу бүс нутаг дэлхийн эх газрын нийт нутгийн 42 хувийг эзлэх бөгөөд энэ бүс нутагт нийт 1,5 тэрбум хүн оршин сууж байна. Цөлжилт, газрын доройтол нь гандуу бүс нутгийн ард иргэдийн амьжиргаа, эрх тэгш байдлыг бууруулах зэрэг эдийн засгийн сөрөг үр дагавар ихтэй бөгөөд түүний эдийн засагт учруулж буй хор хохирол дэлхийн хэмжээнд жилд 42 тэрбум ам.долларт хүрч байна. Одоогийн байдлаар 110 гаруй оронд цөлжилтийн аюулд ямар нэг байдлаар өртөх аюул тулгараад байгаа ба дэлхийн нийт мал сүргийн тал нь хуурай гандуу бүс нутагт байна. Хэрэв хуурай гандуу бүс нутагт хүнсний үйлдвэрлэл уналтанд орвол дэлхийн хүн амын хүнсний бүтээгдэхүүний үнэ огцом өсөх, нийлүүлэлт багасах аюул тулгарах болно.

Өнөөгийн байдлаар, манай орны нутаг дэвсгэрийн 77.8 хувь нь цөлжилтийн сул, дунд, хүчтэй, нэн хүчтэй гэсэн зэрэглэлд өртсөн байна. НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцийн газраас гаргасан тодорхойлолтоор манай орны нийт газар нутгийн 90 орчим хувь нь газрын доройтол, цөлжилтийн аюулд өртөх эмзэг бүс нутагт хамаарагдаж байгаа нь Та биднээс байгаль орчноо хайрлан хамгаалахад хүчин чармайлт гарган ажиллах шаардлагатай болохыг анхааруулж байна. Монгол орны газарзүйн байршлын онцлог, дэлхийн дулаарал зэрэг байгалийн хүчин зүйлээс гадна бэлчээрийн газрын талхагдлыг нэмэгдүүлж буй хүчин зүйлс, ой модны хууль бус хулгай, хөдөө орон нутгийн олон салаа зам харгуй, уул уурхайн ашиглалтын дараах нөхөн сэргээлтийг шаардлагын түвшинд хийхгүй байгаа зэрэг хүний үйл ажиллагаа нь цөлжилтийн цар хүрээг нэмэгдүүлэхэд сөрөг нөлөө үзүүлсээр байна.

Монгол улсын засгийн газар НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх Конвенцийн газраас дэвшүүлсэн 10 жилийн Стратегийн зорилттой уялдуулан Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрөө шинэчлэн хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн нэг гол зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай” хуулийг анх удаа боловсруулан УИХ-аар батлуулсан нь цөлжилттэй тэмцэх эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой ажил болсон.

Цөлжилттэй тэмцэх төрийн бодлого хөтөлбөр, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын бодит оролцоо, хувь нэмэр чухал шаардлагатай болохыг онцлон тэмдэглэж байна.

Цөлжилттэй тэмцэх олон улсын өдрийн мэндчилгээг дэвшүүлэхийн ялдамд “Газрын хөрс бол үнэгүй зүйл биш. Эрүүл хөрсөнд хөрөнгө оруулцгаая!” гэсэн НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцийн 2015 оны уриаг хэрэгжүүлж, цөлжилтийн эсрэг хамтдаа тэмцэхийг Та бүхэнд хандан уриалж байна.